

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн ерөнхий боловсролын хорин ес дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/162/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим
хаяг:naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: С.Нацагдорж
Утас:260512 Цахим хаяг:natsagdorjs@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Оюунтөгөлдөр
Утас:260512 Цахим хаяг:oyuntuguldurg@audit.gov.mn

Цэгцтөв богд аудит ХХК-ийн захирал:Н.Цэрэнханд
Утас: 99901517 Цахим хаяг:tsegtstuvbogd@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/395
танай _____-ны № _____-т

Хязгаарлалтай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын хорин ес дүгээр сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 142,145.1 мянган төгрөгийн зөрчил илэрч бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Анхан шатны бүрдэл дутуу хүчин төгөлдөр бус баримтаар 30,095.8 мянган төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн;
- Засгийн газраас тогтоосон дотуур байрны хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг 19,769.2 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, 16 дугаар зүйлийн 16.5.2, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 13.6, 13.7 дах заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант оны хичээлийн жилд 252 сонсгол, хэл ярианы онцлогтой сурагчид сурч байгаагаас хавсарсан бэрхшээлтэй 60 сурагч, бага ангийн 11 бүлэгт 86 сурагч, дунд ангийн 13 бүлэгт 116 сурагч, ахлах ангийн 7 бүлэгт 50 сурагч суралцаж байна.

Z:\Yawsan_Bichig\2026\0225 SAG-87.Docx

1526140810

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4,628,500.9 мянган төгрөгийн хичээлийн болон дотуур байранд их засварын ажил гүйцэтгүүлж, бусад байгууллагаас хандив, тусламжаар 278,764.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, бараа хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус сургууль нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	72,926,484.65	84,267,322.13
33	АВЛАГА	-	8,576,207.60
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	2,376,207.60
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	6,200,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	72,926,484.65	75,691,114.53
35100	Түүхий эд материал	3,280,969.00	1,939,160.00
35130	Эм боох материал	3,280,969.00	1,939,160.00
35400	Хангамжийн материал	69,645,515.65	73,751,954.53
35410	Бичиг хэргийн материал	151,750.00	1,181,600.00
35420	Аж ахуйн материал	2,415,970.00	1,125,494.00
35440	Түлш, шатах тослох материал	651,304.00	143,464.00
35450	Барилгын засварын материал	-	5,800,000.00
35460	Хүнсний материал	7,732,471.00	11,204,112.20
35470	Бусад хангамжийн материал	58,694,020.65	54,297,284.33
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,456,232,493.19	8,970,617,417.23
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,456,232,493.19	8,970,617,417.23
392	Биет хөрөнгө	4,022,537,133.19	8,536,922,057.23
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,082,676,048.00	8,711,177,023.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(687,688,019.20)	(847,883,600.62)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	126,974,891.00	126,974,891.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(66,944,880.11)	(126,974,891.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	761,443,683.71	933,975,409.89
39206	Хуримтлагдсан элэгдэл	(486,251,523.18)	(594,495,717.37)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	406,768,768.27	503,383,521.79
39208	Хуримтлагдсан элэгдэл	(221,400,460.15)	(263,147,295.51)
39214	Бусад үндсэн хөрөнгө	219,362,587.40	219,362,587.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	(128,890,940.00)	(142,294,848.80)
39217	Ном	16,486,977.45	16,844,977.45
393	Биет бус хөрөнгө	433,695,360.00	433,695,360.00
39303	Бусад биет бус хөрөнгө	433,695,360.00	433,695,360.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,529,158,977.84	9,054,884,739.36
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	3,754,347.10
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	3,754,347.10
413	Өглөг	-	3,754,347.10
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	2,376,207.60
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,378,139.50
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,529,158,977.84	9,051,130,392.26
51	Засгийн газрын хувь оролцоо	4,529,158,977.84	9,051,130,392.26
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,767,655,847.77	2,767,655,847.77
511001	Засгийн газрын оруулсан капитал засгийн газрын сан	2,767,655,847.77	2,767,655,847.77
51200	Хуримтлагдсан үр дүн	(1,276,061,446.27)	3,245,909,968.15
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,146,651,444.98)	(1,331,801,439.88)
51220	Тайлант үеийн үр дүн	(129,410,001.29)	4,577,711,408.03
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,037,564,576.34	3,037,564,576.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,529,158,977.84	9,054,884,739.36

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,303,956,410.82	10,328,807,218.18
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	207,368,545.00	4,907,265,470.18
120	Нийтлэг татварын бус орлого	207,368,545.00	4,907,265,470.18
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	195,989,045.00	4,896,907,654.70
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	11,379,500.00	10,357,815.48
122	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	5,096,587,865.82	5,421,541,748.00
1221	Хандив тусламж /дотоод/	5,051,336,900.00	5,351,072,700.00
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	5,051,336,900.00	5,351,072,700.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,250,965.82	70,469,048.00
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	6,200,000.00
122133	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	43,324,325.00
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	17,148,723.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	45,250,965.82	3,796,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,309,344,583.11	5,751,095,810.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,309,344,583.11	5,751,095,810.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,072,207,733.02	5,462,902,577.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,007,973,880.12	4,274,368,796.50
210101	Үндсэн цалин	2,247,980,523.61	2,433,138,963.84
210102	Нэмэгдэл	1,272,391,184.51	1,373,673,207.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	314,605,725.00	302,927,161.85
210104	Урамшуулал	172,996,447.00	164,629,463.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	496,791,133.59	537,649,683.52
210201	Тэтгэврийн даатгал	351,180,828.84	370,995,933.41
210202	Тэтгэмжийн даатгал	41,040,685.07	42,969,805.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,529,552.62	23,640,042.11
210204	Ажилгүйдлийн даатгал	17,825,554.23	16,073,078.24
210205	Эрүүл мэндийн даатгал	65,214,512.83	83,970,823.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	130,808,600.00	120,093,749.51
210301	Гэрэл, цахилгаан	43,173,807.34	49,654,504.22
210302	Түлш, халаалт	58,089,567.34	53,124,595.26
210303	Цэвэр, бохир ус	29,545,225.32	17,314,650.03
2104	Хангамж, бараа материалын зардал	37,081,182.92	34,576,937.00
210401	Бичиг хэрэг	1,564,350.00	1,400,550.00
210402	Тээвэр, шатахуун	16,008,082.92	5,457,524.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,140,600.00	1,061,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,017,250.00	1,708,370.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,350,900.00	24,948,993.00
2105	Нормативт зардал	70,280,044.00	81,077,346.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,831,864.00	2,942,409.00
210502	Хоол, хүнс	64,948,180.00	76,884,937.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	1,250,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,609,050.00	23,283,440.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,246,000.00	-
210604	Урсгал засвар	8,363,050.00	23,283,440.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,342,278.00	39,214,742.00

**Нийслэлийн ерөнхий боловсролын хорин ес дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,961,448.00	31,860,050.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	395,630.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	121,500.00	606,648.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	256,200.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,107,500.00	1,745,000.00
210807	Газрын төлбөр	-	3,044.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	274,321,564.39	352,637,882.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,346,333.20	20,554,255.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,002,610.00	4,203,090.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	222,972,621.19	327,880,537.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	237,136,850.09	288,193,232.77
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	16,385,273.33	169,256,982.47
21311	Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	16,385,273.33	169,256,982.47
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	16,383,773.33	166,990,582.46
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	1,500.00	2,266,400.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	220,751,576.76	118,936,250.30
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	41,861,225.00	95,519,172.80
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	175,187,463.76	22,214,077.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,702,888.00	1,203,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(5,388,172.29)	4,577,711,408.03
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	124,021,829.00	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	124,021,829.00	-
7	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(124,021,829.00)	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (6)=(3)+(7)	(129,410,001.29)	4,577,711,408.03

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	5,098,078,405.92	5,421,541,748.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,098,078,405.92	5,421,541,748.00
122	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	5,098,078,405.92	5,421,541,748.00
1221	Хандив тусламж /дотоод/	5,051,336,900.00	5,351,072,700.00
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	5,051,336,900.00	5,351,072,700.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	5,051,336,900.00	5,351,072,700.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	46,741,505.92	70,469,048.00
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	6,200,000.00
122133	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	43,324,325.00
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	17,148,723.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	46,741,505.92	3,796,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,090,453,605.92	5,420,443,948.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,090,453,605.92	5,420,443,948.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,816,091,980.83	5,124,159,861.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,009,111,320.96	4,274,368,796.50
210101	Үндсэн цалин	2,235,025,388.39	2,433,138,963.84
210102	Нэмэгдэл	1,286,483,760.57	1,373,673,207.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	314,605,725.00	302,927,161.85
210104	Урамшуулал	172,996,447.00	164,629,463.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	496,301,703.95	537,649,683.52
210201	Тэтгэврийн даатгал	350,043,388.00	370,995,933.41
210202	Тэтгэмжийн даатгал	41,040,685.07	42,969,805.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,529,552.62	23,640,042.11
210204	Ажилгүйдлийн даатгал	17,825,554.23	16,073,078.24
210205	Эрүүл мэндийн даатгал	65,862,524.03	83,970,823.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	130,808,600.00	120,093,749.51
210301	Гэрэл, цахилгаан	43,173,807.34	49,654,504.22
210302	Түлш, халаалт	58,089,567.34	53,124,595.26
210303	Цэвэр, бохир ус	29,545,225.32	17,314,650.03
2104	Хангамж, бараа материалын зардал	35,629,357.92	32,702,136.50
210401	Бичиг хэрэг	1,669,400.00	2,430,400.00
210402	Тээвэр, шатахуун	13,896,857.92	4,447,284.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,140,600.00	1,061,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,017,250.00	1,78,370.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,905,250.00	23,054,582.50
2105	Нормативт зардал	75,126,900.00	85,110,213.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,999,600.00	1,600,600.00
210502	Хоол, хүнс	68,208,600.00	81,340,013.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,918,700.00	2,169,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,728,300.00	29,223,640.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,246,000.00	140,200.00
210604	Урсгал засвар	9,482,300.00	29,083,440.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,450,498.00	39,444,742.00

**Нийслэлийн ерөнхий боловсролын хорин ес дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,069,668.00	32,090,050.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	395,630.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	121,500.00	606,648.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	256,200.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,107,500.00	1,745,000.00
210807	Газрын төлбөр		3,044.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,935,300.00	5,566,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,111,900.00	1,850,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,823,400.00	3,716,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	274,361,625.09	296,284,086.97
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	16,385,273.33	175,456,982.47
21311	Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	16,385,273.33	175,456,982.47
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	16,383,773.33	166,990,582.46
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	1,500.00	2,266,400.01
2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		6,200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	257,976,351.76	120,827,104.50
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	79,086,000.00	97,410,027.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	175,187,463.76	22,214,077.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,702,888.00	1,203,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	7,624,800.00	1,097,800.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,624,800.00	1,097,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,624,800.00	1,097,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,624,800.00	1,097,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,624,800.00	1,097,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(7,624,800.00)	(1,097,800.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	1.Засгийн газрын оруулсан капитал	1.2.Дахин үнэлгээний нөөц	1.3.Хуримтлагдсан дүн	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,767,655,847.77	3,037,564,576.34	(1,146,980,144.84)	4,658,240,279.27
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	328,699.86	328,699.86
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,767,655,847.77	3,037,564,576.34	(1,146,651,444.98)	4,658,568,979.13
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(129,410,001.29)	(129,410,001.29)
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,767,655,847.77	3,037,564,576.34	(1,276,061,446.27)	4,529,158,977.84
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(55,739,993.61)	(55,739,993.61)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,767,655,847.77	3,037,564,576.34	(1,331,801,439.88)	4,473,418,984.23
19	Тайлант үеийн үр дүн	-	-	4,577,711,408.03	4,577,711,408.03
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,767,655,847.77	3,037,564,576.34	3,245,909,968.15	9,051,130,392.26

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,362,931,100.00	5,184,082,117.54	178,848,982.46	96.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,362,931,100.00	5,184,082,117.54	178,848,982.46	96.7
122	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	5,362,931,100.00	5,184,082,117.54	178,848,982.46	96.7
122005	Төсвөөс санхүүжих	5,362,931,100.00	5,184,082,117.54	178,848,982.46	96.7
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,362,931,100.00	5,184,082,117.54	178,848,982.46	96.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,362,931,100.00	5,184,082,117.54	178,848,982.46	96.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,232,607,500.00	5,063,255,013.04	169,352,486.96	96.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,359,817,300.00	4,265,360,213.51	94,457,086.49	97.8
210101	Үндсэн цалин	2,367,672,400.00	2,424,130,380.85	(56,457,980.85)	102.4
210102	Нэмэгдэл	1,627,936,500.00	1,373,673,207.56	254,263,292.44	84.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	235,224,000.00	302,927,161.85	(67,703,161.85)	128.8
210104	Урамшуулал	128,984,400.00	164,629,463.25	(35,645,063.25)	127.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	549,157,300.00	537,649,683.52	11,507,616.48	97.9
210201	Тэтгэврийн даатгал	373,426,900.00	370,995,933.41	2,430,966.59	99.3
210202	Тэтгэмжийн даатгал	43,932,600.00	42,969,805.92	962,794.08	97.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,966,300.00	23,640,042.11	(1,673,742.11)	107.6
210204	Ажилгүйдлийн даатгал	21,966,300.00	16,073,078.24	5,893,221.76	73.2
210205	Эрүүл мэндийн даатгал	87,865,200.00	83,970,823.84	3,894,376.16	95.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	147,905,400.00	120,093,749.51	27,811,650.49	81.2
210301	Гэрэл, цахилгаан	50,203,100.00	49,654,504.22	548,595.78	98.9
210302	Түлш, халаалт	64,770,000.00	53,124,595.26	11,645,404.74	82.0
210303	Цэвэр, бохир ус	32,932,300.00	17,314,650.03	15,617,649.97	52.6
2104	Хангамж, бараа материалын зардал	24,244,800.00	20,975,811.50	3,268,988.50	86.5
210401	Бичиг хэрэг	2,394,500.00	2,430,400.00	(35,900.00)	101.5
210402	Тээвэр, шатахуун	3,327,300.00	3,887,284.00	(559,984.00)	116.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,907,700.00	1,061,500.00	1,846,200.00	36.5
210404	Ном, хэвлэл	58,000.00	358,000.00	(300,000.00)	617.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,878,800.00	1,708,370.00	2,170,430.00	44.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,678,500.00	11,530,257.50	148,242.50	98.7
2105	Нормативт зардал	110,725,700.00	84,140,613.00	26,585,087.00	76.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,590,500.00	1,600,600.00	1,989,900.00	44.6
210502	Хоол, хүнс	105,935,200.00	81,340,013.00	24,595,187.00	76.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,200,000.00	1,200,000.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,783,500.00	16,783,440.00	60.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	500,000.00	500,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	16,283,500.00	16,283,440.00	60.00	100.0

**Нийслэлийн ерөнхий боловсролын хорин ес дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,310,400.00	12,304,602.00	4,005,798.00	75.4
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	4,950,000.00	4,949,910.00	90.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	279,000.00	-	279,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо	1,188,100.00	606,648.00	581,452.00	51.1
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	296,300.00	-	296,300.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,489,500.00	1,745,000.00	2,744,500.00	38.9
210807	Нийтлэг үйлчилгээний төлбөр, хураамж	107,500.00	3,044.00	104,456.00	2.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,663,100.00	5,946,900.00	1,716,200.00	77.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,850,400.00	1,850,400.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,812,700.00	4,096,500.00	1,716,200.00	70.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	130,323,600.00	120,827,104.50	9,496,495.50	92.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	130,323,600.00	120,827,104.50	9,496,495.50	92.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	106,904,200.00	97,410,027.00	9,494,173.00	91.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,216,400.00	22,214,077.50	2,322.50	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,203,000.00	1,203,000.00		100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО		1		100.0
610001	Төсвийн байгууллага		1		100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО		136	132	4
620001	Удирдах ажилтан		1	1	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан		75	78	(3)
620003	Үйлчлэх ажилтан		60	53	7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН		70,469,048.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		70,469,048.00
122	Тусламжийн орлого		70,469,048.00
1221	Хандив, тусламж /дотоод/		70,469,048.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		70,469,048.00
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		6,200,000.00
350013	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		43,324,325.00
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		17,148,723.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		3,796,000.00
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		62,002,647.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ		62,002,647.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		62,002,647.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		9,008,582.99
210101	Үндсэн цалин		9,008,582.99
2104	Хангамж, бараа материалын зардал		12,084,325.00
210402	Тээвэр, шатахуун		560,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		11,524,325.00
2105	Нормативт зардал		969,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		969,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		12,800,000.00
210604	Урсгал засвар		12,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		27,140,140.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		27,140,140.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		8,466,400.01
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		8,466,400.01
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт		8,466,400.01

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн ерөнхий боловсролын хорин есдүгээр сургууль нь сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүүхдийг 21 аймаг 9 дүүргээс элсүүлэн авч, өөрийн дотуур байранд амьдруулан, хэл ярианы ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдэд ерөнхий боловсрол олгодог улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тус сургууль нь эрхэм зорилгоо “хос хэл соёл, уламжлалт сургалтын арга зүйг хослуулж, эцэг эх, багш, сургуулийн хамтын ажиллагаанд тулгуурлаж, хүүхэд бүрийн хөгжлийг дэмжсэн сургалт арга зүйн үндэсний загварыг бий болгоно” гэж тодорхойлсон байна. Дэвшүүлсэн эрхэм зорилгын хүрээнд дараах зорилгыг тавьж ажиллаж байна. Үүнд:

- Сурагчдын логик сэтгэлгээг хөгжүүлэх, шинжлэн судлах арга барил эзэмшихэд дэмжлэг үзүүлэх;
- Дотуур байранд хүүхэд аюулгүй амьдрах, сурах, хөгжих, төлөвших таатай орчин бүрдүүлэх;
- Суралцагчдын нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх нийгэмшүүлэх;
- Багшийн ёс зүйг мөрдөж, хамтын үйл ажиллагаанд тулгуурлах, багшийн хөгжил, бүтээлч үйл ажиллагааг дэмжих;
- Сургалтын орчин, суралцах нөхцөлийг сайжруулах, сургалтын чанарыг үр дүнд тулгуурлан сайжруулах;
- Сургуулийн менежментийг сайжруулах, хүүхэд хамгааллын бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх.

Тайлант оны хичээлийн жилд 252 сонсгол, хэл ярианы онцлогтой суралцагчид сурч байгаагаас хавсарсан бэрхшээлтэй 60 суралцагч суралцаж байна. Бага ангийн 11 бүлэгт 86 сурагч, дунд ангийн 13 бүлэгт 116 сурагч, ахлах ангийн 7 бүлэгт 50 сурагч суралцдаг.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус сургууль нь үйл ажиллагаандаа Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн хэмнэлтийн хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолоор баталсан “Тусгай сургалтын байгууллагын зардал тооцох, зарим албан тушаалтанд нэмэгдэл нэмэгдэл хөлс олгох журам”-уудыг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах нэмэлт өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Засгийн газрын “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2024 оны 238 дугаар тогтоол;
- Засгийн газрын “Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2024 оны 254 дүгээр тогтоол;

- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Боловсролын яамны салбарын хяналт шинжилгээ үнэлгээний газраас тайлант онд тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаа, Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт хийгээгүй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн ерөнхий боловсролын хорин ес дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус сургууль нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/22 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа боловч бодлогын баримт бичиг нь 2021 оноос хойш өөрчлөлт ороогүй, салбарын үйл ажиллагааны онцлогийг нарийвчлан тусгаагүй, ерөнхий байдлаар боловсруулсан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэлийн ерөнхий боловсролын хорин ес дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,525,725.7 мянган төгрөгөөр буюу 99.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага		8,576.2	8,576.2
Бараа материал	72,926.5	75,691.1	2,764.6
Үндсэн хөрөнгө	4,456,232.5	8,970,617.4	4,514,384.9
Нийт хөрөнгө	4,529,159.0	9,054,884.7	4,525,725.7
Өр төлбөр	-	3,754.3	3,754.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,529,159.0	9,051,130.4	4,521,971.4

Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,529,159.0	9,054,884.7	4,525,725.7
---------------------------------------	-------------	-------------	-------------

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Тухайлбал:

- Авлага дансны үлдэгдэл 8,576.2 мянган төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлт 2,376.2 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн татаас санхүүжилтийн 6,200.0 мянган төгрөгийн авлага үүссэнтэй холбоотой;
- Бараа материалын дансны үлдэгдэл 75,691.1 мянган төгрөг болж, 2,764.6 мянган төгрөгөөр өссөн нь сургуулийн хэвийн үйл ажиллагааг явуулахад зориулан 248,579.9 мянган төгрөгийн худалдан авалт хийж, хандив тусламжаар 10,357.8 мянган төгрөг бараа материал авч, 256,173.0 мянган төгрөгийн материал зарцуулсан;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 4,514,384.9 мянган төгрөгөөр өссөн нь 4,628,500.9 мянган төгрөгийн хичээлийн болон дотуур байрны их засварыг нийслэлийн хөрөнгө оруулалтаар, 1,097.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг урсгал төсвийн хөрөнгө оруулалтаар, 113,999.1 мянган төгрөгийн хөрөнгийг Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслөөс, 147,658.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хандиваар хүлээн авч, тайлант онд 383,620.5 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон зэрэг нь голлон нөлөөлсөн;
- Өр төлбөр дансны үлдэгдэл 3,754.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ажиллагчидтай холбогдсон өглөг 2,376.2 мянган төгрөг, бусад зардлын тооцооны өглөг 1,378.1 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой;
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4,524,347.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 6,005,378.5 мянган төгрөг, нийт зарлагыг 6,005,378.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт зардлыг 629,499.8 мянган төгрөгөөр бууруулж, 5,375,878.7 мянган төгрөгөөр баталжээ. Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх 528,087.0 мянган төгрөг, хангамж бараа материалын худалдан авах 30,622.9 мянган төгрөг, нормативт 33,572.6 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг 37,217.3 мянган төгрөгөөр зардлыг тус тус бууруулж хянаснаас шалтгаалсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг тодотголоор 12,947.6 мянган төгрөгөөр бууруулж, ерөнхий боловсролын хөтөлбөрийн 4 арга хэмжээний 5,362,931.1 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,351,072.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 5,184,082.1 мянган төгрөг зарцуулж, үлдэгдэл 166,990.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,184,082.1 мянган төгрөг буюу 96.7 хувьтай байгаа нь орон тоо дутуу ажилласантай холбоотой цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 94,457.1 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 11,507.6 мянган төгрөг, байр ашиглалтай холбоотой тогтмол зардлыг 27,811.6 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 3,269.0 мянган төгрөг, нормативт зардлыг 26,585.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн төлбөр хураамжийн зардлыг 4,005.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,716.2 мянган төгрөг, урсгал шилжүүлгийг 9,496.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
1	71802 Ерөнхий боловсрол	5,362,931.1	5,184,082.1	178,849.0	96.7
2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	23,419.4	23,417.1	2.3	99.9
3	81801 Үдийн цай хөтөлбөр	106,904.2	97,410.0	9,494.2	91.1
4	81806 Дотуур байрны үйлчилгээ	105,935.2	81,340.0	24,595.2	76.8
5	81847 Тусгай хэрэгцээт боловсрол	5,126,672.3	4,981,915.0	144,757.3	97.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Тухайлбал:

Нэг хүнд ногдох 1 өдрийн хоолны зардал 10.0 мянган төгрөг, унааны зардал 1.0 мянган төгрөг байхаар захирлын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/01 дүгээр тушаалаар баталсан байна. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын төсөв 235,224.0 мянган төгрөгөөр батлагдсанаас 302,927.2 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар ажлаас үндэслэлгүй халагдсан нэр бүхий 2 албан тушаалтанд нөхөн олгосон цалин 20,513.8 мянган төгрөгийг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлж зөрчлийг арилгах, албан шаардлагыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгжид хариуцуулсан ч биелэлт хангагдаагүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас 43,324.3.0 мянган төгрөг, Нийслэлийн боловсролын газраас 17,148.7 мянган төгрөг, Фило ХХК-ийн хандиваар 6,200.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын нэмэлт орлогоор 3,796.0 мянган төгрөг, нийт 70,469.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 9,008.6 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 12,084.3 мянган төгрөг, нормативт зардалд 969.6 мянган төгрөг, урсгал засварт 12,800.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 27,140.1 мянган төгрөг, нийт 62,002.6 мянган төгрөгийг зарцуулж, 8,466.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Фило ХХК-ийн хандивын 6,200.0 мянган төгрөгийг буцааж авахаар тооцоо нийлж, татаас санхүүжилтийн авлагаар санхүүгийн байдлын тайланд тусгасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус сургуулийн 2025 оны батлагдсан төсөвт дотуур байрны хүүхдийн хоолны зардал 106,200.0 мянган төгрөг, үдийн хоолны зардал 107,100.0 мянган төгрөг нийт 213,300.0 мянган төгрөг тусгагдсан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу төлөвлөж, тайлагнаагүй байна. Тус сургууль нь 2025 онд хүнсний материалын худалдан авах ажиллагааг 319,942.6 мянган төгрөгөөр төлөвлөж, батлагдсан төсвөөс 106,642.6 мянган төгрөгөөр илүү худалдан авалт хийхээр баталсан. Шууд худалдан авалтын гэрээг он дамжуулан байгуулж, үнийн дүн тусгаагүй 134,446.2 мянган төгрөгийн худалдан авалтад гэрээг дүгнэж ажиллаагүй байна.

Ерөнхий гэрээний аргаар цахим дэлгүүрээс 43,303.9 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын хорин ес дүгээр сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Нийслэлийн ерөнхий боловсролын хорин ес дүгээр сургууль, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Цэгцтөв богд аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Өлзий-Орших, туслах аудитор П.Пунцаг нар гүйцэтгэж, аудитын менежер Т.Энхцэцэг, захирал Н.Цэрэнханд нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Оюунтөгөлдөр, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн ерөнхий боловсролын хорин ес дүгээр сургууль нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 02 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр үйл ажиллагааны зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын 5,433,366.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 54,333.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль, Улсын Их Хурлын 2025 оны 48 дугаар тогтоол шийдвэр гарсантай холбоотойгоор байгууллага тэвчиж болох дараах зардлыг хэмнэж ажилласан байна. Тухайлбал:

- Байгууллагын бүтэц орон тоог 17 хүнээр бууруулан, тэтгэвэрт гарсан ажилчдын оронд хүн авалгүй, ажил хавсруулан гүйцэтгүүлж 133 хүний орон тоотой ажиллаж цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас 94,457.1 мянган төгрөг;
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас 11,507.6 мянган төгрөг;
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 27,811.6 мянган төгрөг;
- Хангамж бараа материалын зардлаас 3,268.9 мянган төгрөг;
- Нормативт зардлаас 26,585.1 мянган төгрөг;
- Бусдаар гүйцэтгүүлсэн төлбөр хураамжийн зардлаас 4,005.8 мянган төгрөг;
- Бараа үйлчилгээний бусад зардлаас 1,716.2 мянган төгрөг;
- Бусад урсгал шилжүүлгийн зардлаас 9,496.5 мянган төгрөг тус тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 93 мэдээллээс 51 мэдээллийг хугацаа хоцроож, 421,919.1 мянган төгрөгийн 13 мэдээллийг шилэн дансанд байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд иж бүрэн байршуулж байх албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд дотуур байрны хүүхдийн хоол, үдийн хоолны төсвийг хэтрүүлэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулаагүй, батлагдсан маягтын дагуу төлөвлөгөө, тайланг бэлтгээгүй, худалдан авсан гэрээнд үнийн дүн тусгаагүй, 134,446.2 мянган төгрөгийн худалдан авалтад гэрээг дүгнэж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 48 дугаар зүйлийн 48.2.1 "худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах", 48.2.3 "үнэлгээний хорооны зөвлөмж хууль тогтоомжид нийцэх эсэхэд хяналт тавих", 48.2.8 "энэ хуульд зааснаар худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах", 50.3 "Үнэлгээний хорооны гишүүн худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан байна" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөөгүй, зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, журамд, шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалтай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, худалдан авах ажиллагаа, мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, цалин хөлс, нэмэгдэл цалин ээлжийн амралт, түлш шатахуун дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлээ.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 119,188.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 3 зөвлөмж өгч, 3 албан шаардлагыг жилийн эцсийн аудитаар баталгаажуулж хүргүүлээ.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон 2 албан шаардлага, 3 зөвлөмжийн хэрэгжилт 60.0 хувьтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	20,513.8	1	-	50.0
Зөвлөмж	3	4,900.0	2	4,900.0	66.7
Нийт дүн	5	25,413.8	3	4,900.0	60.0

Ажлаас үндэслэлгүй халагдсан 2 ажилтанд шүүхийн шийдвэрээр байгууллагаас олгосон ба буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгжид хариуцуулсан албан шаардлага болон шилэнд дансны нэгдсэн цахим хуудсад байршуулбал зохих мэдээллийг ил тод хугацаанд нь байршуулж ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлээгүйд албан шаардлага хүргүүлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” -ын талаар нягтлан бодогч нарт сургалт зохион байгуулах, Санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн маягыг Сангийн яамны и-хуулгын хяналтын эдийн засгийн ангилал, бүлгийн тайлантай уялдуулах, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тодруулгыг иж бүрэн бэлтгэж ирүүлэхэд анхаарах.
2. Төсвийн төлөвлөлтийг үндэслэлтэй хийж хянуулах, шаардлагатай төсвийн тооцоо судалгааг нарийвчлан гаргаж хүргүүлдэг байх.
3. Төсөв, санхүү, хөрөнгийн ашиглалт, хамгаалалт зарцуулалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн хяналт үнэлгээ, шинжилгээ дотоод аудитаас хяналт тавьж, зөвлөгөө зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулдаг байх.
4. Ажлаас үндэслэлгүй халагдсан 2 ажилтанд шүүхийн шийдвэрээр байгууллагаас төлсөн төлбөрийг буруутай албан тушаалтнаар төлүүлэх албан шаардлага хэрэгжээгүй байгааг Төрийн албаны зөвлөлд өгч шийдвэрлүүлэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 70,124.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 70,124.8 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн байдлын тайланд нийгмийн даатгалын байгууллагад илүү төлсөн 2,376.2 мянган төгрөгийг авлагаар тайлагнаагүй;
- Нэмэлт санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдлээс тооцоо нийлж баталгаажуулсан 6,200.0 мянган төгрөгийн авлагыг үр дүнгийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгээр тусгасан;
- Үр дүнгийн тайланд "Үдийн хоол" буюу төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардлыг 41,691.4 мянган төгрөгөөр дутуу, бараа ажил үйлчилгээний зардлыг 41,691.4 мянган төгрөгөөр илүү тусгасан;
- Мөнгөн гүйлгээний тайланд ФИЛО ХХК-аас өгсөн хандив 6,200.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 13,277.2 мянган төгрөг нийт 19,477.2 мянган төгрөгийг төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор эдийн засгийн ангилал зөрүүлж тайлагнасан;
- Мөнгөн гүйлгээний тайланд биет болон биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг 1,097.8 мянган төгрөгөөр тайлагнасан байхад үндсэн хөрөнгийн тайланд 380.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгийг дутуу бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна", 15.2 "нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна", УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга 27, 29 дүгээр параграфт заасантай тус тус нийцэхгүй байсныг залруулсан.

Аудитаар нийт 142,145.1 мянган төгрөгийн 6 зөрчил² илэрсэнд, 109,608.4 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 32,536.7 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 142,145.1 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 87,811.4 мянган төгрөгөөс давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

Илрүүлэлт1. Засгийн газраас тогтоосон дотуур байрны хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээнээс 19,769.2 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 41 дүгээр зүйлийн 41.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байгаа эсэхийг хянах", Засгийн газрын 2024 оны "Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 254 дугаар тогтоолын 2.Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах дунд болон ахлах ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6300/ зургаан мянга гурван зуун/төгрөгөөр, бага ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6000/ зургаан мянган/ төгрөгөөр тус тус тогтоосугай" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Засгийн газрын тогтоолоор баталсан дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг хэт рүүлэн зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт2. Багш, ажилчдад илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгохдоо Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ыг баримтлалгүй, нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсыг хөтлөлгүй, илүү цагийн 88,339.2 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын Гурав. Нэмэгдэл хөлс олгох 1. "Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгохдоо нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсыг хөтлөхгүй байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт3. Тус сургуулийн 60 жилийн ойн контент бүтээхтэй холбоотой зардалд 1,500.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1"Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.4 "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх" гэж заасныг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь:

Төсвийг хууль тогтоомж, заавар, журамд нийцүүлэн зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэйгээр зарцуулж байх, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, тодруулгатай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Гэрэл цахилгааны зардлаас цэвэр бохир усны зардалд 939.9 мянган төгрөг, Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал зардлаас 808.4 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээний бусад зардлаас 569.2 мянган төгрөгийг бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардалд, бараа үйлчилгээний бусад зардлаас 101.6 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн зардлаас 21.8 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрүүлэн нийт 2,440.9 мянган төгрөгийг зарцуулжээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.7 "Энэ хуулийн 22.2-т заасан төсвийн ангиллын төрөл бүрээр дэлгэрэнгүй ангилал тогтоох, түүнийг төсвийн төлөвлөлт, тайлагналт, гүйцэтгэлд ашиглах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно", Сангийн сайдын 2023 оны А/211 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал" -д заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулахдаа холбогдох дээд шатны байгууллагаас зөвшөөрөл авч, гүйцэтгэлийг бодитой тайлагнаж байх.

Илрүүлэлт 2: Тайлант онд анхан шатны бүрдэл дутуу баримтаар 30,095.8 мянган төгрөгийн 62 ажил гүйлгээгээр бичиг хэрэг, эм, түлш шатахуун, бусад хангамжийн материалыг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг бүртгэхгүй байх.

Илрүүлэлт 3.

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 742,843.2 мянган төгрөгийн 727 нэр төрлийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, холбогдох байгууллагад хүсэлт өгч шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2" Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн байдлын тайланд нийгмийн даатгалын байгууллагад илүү төлсөн 2,376.2 мянган төгрөгийг авлагаар тайлагнаагүй байна	1	2,376.2	1	2,376.2			1	2,376.2	-	-	-	-
Нэмэлт санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдлээс тооцоо нийлж баталгаажуулсан 6,200.0 мянган төгрөгийн авлагыг үр дүнгийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгээр тайлагнасан	1	6,200.0			1	6,200.0	1	6,200.0	-	-	-	-
Үр дүнгийн тайланд "Үдийн хоол" буюу төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардлыг 41,691.4 мянган төгрөгөөр дутуу, бараа ажил үйлчилгээний зардлыг 41,691.4 мянган төгрөгөөр илүү тусгасан байна	1	41,691.4			1	41,691.4	1	41,691.4	-	-	-	-
Мөнгөн гүйлгээний тайланд ФИЛО ХХК-аас өгсөн хандив 6,200.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 13,277.2 мянган төгрөг нийт 19,477.2 мянган төгрөгийг төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор эдийн	1	19,477.2			1	19,477.2	1	19,477.2	-	-	-	-

засгийн ангилал зөрүүлж тайлагнасан байна.												
Мөнгөн гүйлгээний тайланд биет болон биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг 1,097.8 мянган төгрөгөөр тайлагнасан байхад үндсэн хөрөнгийн тайланд 380.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгийг дутуу бүртгэсэн байна	1	380.0			1	380.0	1	380.0				
	5	70,124.8	1	2,376.2	4	67,748.6	5	70,124.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тус сургууль нь дотуур байрны хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг 19,769.2 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.	1	19,769.2			1	19,769.2						
Багш, ажилчдад илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгохдоо Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-аар нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсыг хөтлөлгүй илүү цагийн 88,339.2 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон байна.	1	88,339.2			1	88,339.2						

Тус сургуулийн 60 жилийн ойн контент бүтээхтэй холбоотой зардалд 1,500.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	1,500.0			1	1,500.0					
Гэрэл цахилгааны зардлаас цэвэр бохир усны зардалд 939.9 мянган төгрөг, Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал зардлаас 808.4 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээний бусад зардлаас 569.2 мянган төгрөгийг бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардалд, бараа үйлчилгээний бусад зардлаас 101.6 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн зардлаас 21.8 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрүүлэн нийт 2,440.9 мянган төгрөгийг зарцуулсан.	1	2,440.9					1	2,440.9			
Тус сургууль нь бичиг хэрэг, эм, түлш шатахуун, бусад хангамжийн материалыг зарцуулахдаа анхан шатны баримт бүрдэл дутуу 62 баримтаар 30,095.8 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн	1	30,095.8					1	30,095.8			
Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 727 нэр төрлийн 742,843.2 мянган төгрөгийн хөрөнгөнд дахин үнэлгээ хийгээгүй байгаа	1	-					1	-			
Дүн	6	142,145.1			3	109,608.4	3	32,536.7			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
1	Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 93 мэдээллээс мэдээлсэн 78, хугацаа хоцроож мэдээлсэн 51 мэдээлэл, 421,919.1 мянган төгрөгийн 13 мэдээллийг шилэн дансанд байршуулаагүй байна.	1	421,919.1	1	421,919.1	-	-
	Дүн	1	421,919.1	1	421,919.1		
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд дотуур байрны хүүхдийн хоол, үдийн хоолны төсвийг хэтрүүлэн худалдан авах төлөвлөгөө хийсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулаагүй, батлагдсан маягтын дагуу төлөвлөгөө, тайланг бэлтгээгүй, шууд худалдан авсан гэрээнд үнийн дүн тусгаагүй, 134,446.2 төгрөгийн худалдан авалтад гэрээг дүгнэж ажиллаагүй байна.	1	134,446.2	1	134,446.2	-	-
	Дүн	1	134,446.2	1	134,446.2	-	-
	Нийт дүн	2	556,365.3	2	556,365.3	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 444/А0150458

Улаанбаатар хот

САГ-2026/162/НА -СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын хорин ес дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газраас тогтоосон дотуур байрны хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг 19,769,138.80 /арван есөн сая долоон зуун жаран есөн мянга нэг зуун гучин найман/ төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 41 дүгээр зүйлийн 41.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Засгийн газрын 2024 оны "Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 254 дугаар тогтоолын 2.Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах дунд болон ахлах ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6300/ зургаан мянга гурван зуун/төгрөгөөр, бага ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6000/ зургаан мянган/ төгрөгөөр тус тус тогтоосугай" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 " хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын тогтоолоор баталсан дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг хэтрүүлэн зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын хорин ес дүгээр сургуулийн захирал /С.Батмягмар/, ахлах нягтлан бодогч /Г.Мөнхгэрэл/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц НАРАНЧИМЭГ
С НАЦАГДОРЖ
Н ЦЭРЭНХАНД



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

9025031411

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-81.Docx

1526180990



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 443/А0150458

Улаанбаатар хот

САГ-2026/162/КА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын хорин ес дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Багш, ажилчдад илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгохдоо Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ыг баримтлаагүй, нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсыг хөтлөлгүй 88,339,234.00 /Наян найман сая гурван зуун гучин есөн мянга хоёр зуун гучин дөрвөн/ төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын Гурав. Нэмэгдэл хөлс олгох 1. "Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгохдоо нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсыг хөтлөхгүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын хорин ес дүгээр сургуулийн захирал /С.Батмягмар/, ахлах нягтлан бодогч /Г.Мөнхгэрэл/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
ЦЭРЭНХАНД

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

9026109
4741005
902598141

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-81.Docx

1526180992



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 442/А0150458

Улаанбаатар хот

САГ-2026/162/НА - [ТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын хорин ес дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус сургуулийн 60 жилийн ойн контент бүтээхтэй холбоотой зардалд 1,500,000.00 нэг сая таван зуун мянган/ төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.4 "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг хууль тогтоомж, заавар, журамд нийцүүлэн зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэйгээр зарцуулахгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын хорин ес дүгээр сургуулийн захирал /С.Батмягмар/, ахлах нягтлан бодогч /Г.Мөнхгэрэл/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Н.ЦЭРЭНХАНД



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-81.Docx

1526180994



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 441/А0150458

Улаанбаатар хот

САГ-2026/162/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын хорин ес дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд дотуур байрны хүүхдийн хоол, үдийн хоолны төсвийг хэтрүүлэн төлөвлөгөө боловсруулсан, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулаагүй, батлагдсан маягтын дагуу төлөвлөгөө, тайланг бэлтгээгүй, шууд худалдан авсан гэрээнд үнийн дүн тусгаагүй, 134,446,186.00 /нэг зуун гучин дөрвөн сая дөрвөн зуун дөчин зургаан мянга нэг зуун наян зургаан/ төгрөгийн худалдан авалтад гэрээг дүгнэж ажиллаагүй байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 48 дугаар зүйлийн 48.2.1 "худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах", 48.2.3 "үнэлгээний хорооны зөвлөмж хууль тогтоомжид нийцэх эсэхэд хяналт тавих", 48.2.8 "энэ хуульд зааснаар худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах", 50.3 "Үнэлгээний хорооны гишүүн худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан байна" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хуулийн дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөөгүй, зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын хорин ес дүгээр сургуулийн захирал /С.Батмягмар/, ахлах нягтлан бодогч /Г.Мөнхгэрэл/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
ЭНХЭН ЦЭРЭНХАНД

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z: Alban Sheardlaga\2026\0125 SAG-81.Docx

1526180996



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 440/A0150458

Улаанбаатар хот

САГ - 2026/162/НА - СТА - ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын хорин ес дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудаст 51 мэдээллийг хугацаа хоцроож, 421,919,111.00 /дөрвөн зуун хорин нэгэн сая есөн зуун арван есөн мянга нэг зуун арван нэгэн/ төгрөгийн 13 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлэхгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын хорин ес дүгээр сургуулийн захирал /С.Батмягмар/, ахлах нягтлан бодогч /Г.Мөнхгэрэл/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Н.ЦЭРЭНХАНД